МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ
ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

ББСБ нь МУТС эрсдэлийн үнэлгээг дараах чиглэлээр хийнэ. Үүнд:

1. Харилцагчийн эрсдэл;
2. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнийг харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарах эрсдэл;
3. Газар зүйн байршил, бүс нутгийн эрсдэл;

МУТС эрсдэлийг үнэлэхдээ чиглэл бүрийн үнэлгээний хүчин зүйлсийн үзүүлэлтүүдэд харгалзах оноогоор үнэлж, нийт онооны дүнгээс хамааруулан үнэлгээг бага эрсдэлтэй (L-Low), Дунд эрсдэлтэй (M-Moderate), Өндөр эрсдэлтэй (H-High) гэсэн 3 ангилалд хуваана.

Нэг. Харилцагчийн эрсдэлийг үнэлэх

Тус эрсдэлийг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:

- Монгол Улсад амьдардаггүй, оршин суугч бус харилцагч, гадаадын иргэн, хуулийн этгээд;
- Гадаад улсаас биеэр ирэлгүй санхүүгийн үйлчилгээ авч байгаа харилцагч;
- Хөрөнгө удирдах хэлцлийн дагуу бусдын хөрөнгийг хариуцаж үйлчилгээ авч буй;
- Ойлгоход төвөгтэй өмчлөлийн хэлбэртэй хуулийн этгээд, эсхүл нэрлэсэн хувьцаа эзэмшигч, дамжуулах хувьцаа гаргадаг хуулийн этгээд бол.

Дээрхээс гадна харилцагчийн эрсдэлийн үнэлгээнд түүний ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагааны чиглэл, авч буй бүтээгдэхүүн үйлчилгээ, гүйлгээний онцлогийг харгалзана.

Хүснэгт 1

№	Үнэлгээ	Тайлбар
1	Бага эрсдэлтэй (L-Low)	Харилцагч нь удаан хугацаанд тогтвортой харилцаж байгаа, хувийн мэдээлэл бүрэн, ажил эрхлэлт тодорхой бөгөөд МУТС үйл ажиллагаанд өртөх эрсдэл бага, авч байгаа бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл бага эсвэл дунд, гүйлгээний хэв шинж нь тодорхой
2	Дунд эрсдэлтэй (M-Moderate)	Харилцагч нь дунд хугацаанд харилцаж байгаа, хувийн мэдээлэл бүрэн, ажил эрхлэлт тодорхой бөгөөд МУТС үйл ажиллагаанд өртөх эрсдэл дунд, авч байгаа бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл дунд, гүйлгээний хэв шинж харилцан адилгүй
3	Өндөр эрсдэлтэй (H-High)	Харилцагч нь 3 сар хүртэлх хугацаанд харилцаж байгаа, эсвэл урт хугацаанд харилцаж байгаа ч идэвхтэй биш, хувийн мэдээлэл бүрэн бус, ажил эрхлэлт тодорхойгүй эсвэл МУТС үйл ажиллагаанд өртөх эрсдэлтэй үйл ажиллагаа эрхэлдэг, авч байгаа бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл дунд эсвэл өндөр, гүйлгээний хэв шинж тодорхойгүй бөгөөд биечлэн ирж байгаагүй.

Хоёр. Бүтээгдэхүүн, үйлчилгээний болон түүнийг харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарах эрсдэлийг үнэлэх

Тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог, үйл ажиллагааны урсгал, хяналтын тогтолцоо, харилцагчид хүргэх суваг зэргийг үнэлгээнд хамруулна. Үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэж буй сувгийн эрсдэлийг үнэлэх бол шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, техник технологи нэвтрүүлэх, шинэчлэн сайжруулахтай холбоотойгоор бүтээгдэхүүн үйлчилгээнд нэмэлт өөрчлөлт орох тохиолдолд мөн тэдгээрийн эрсдэлийг үнэлнэ.

Тус эрсдэлийг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:

- Салбар, үйлчилгээний төвөөр дамжуулан үзүүлсэн үйлчилгээ
- Аппликейшнаар дамжуулан үзүүлсэн үйлчилгээ
- Салбар, зуучлагчаар дамжуулан үзүүлсэн үйлчилгээ
- Харилцагч өөрөө бус гуравдагч этгээдээр дамжуулан бүтээгдэхүүн, үйлчилгээг авсан

Хүснэгт 2

№	Үнэлгээ	Тайлбар
1	Бага эрсдэлтэй (L-Low)	Тухайн бүтээгдэхүүн үйлчилгээ нь МУТС үйл ажиллагаанд ашиглагдах эрсдэл бага, үйл ажиллагааны урсгал нь дараалсан хяналтын тогтолцоотой, харилцагчид хүргэх суваг нь зөвшөөрөгдсөн, тодорхой, харилцагч биечлэн ирэлгүй тухайн бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломжгүй, эсхүл хуульд зөвшөөрсөн хэлбэрээр цахимаар тухайн үйлчилгээг авч байгаа.
2	Дунд эрсдэлтэй (M-Moderate)	Тухайн бүтээгдэхүүн үйлчилгээ нь МУТС үйл ажиллагаанд ашиглагдах эрсдэл дунд, үйл ажиллагааны урсгал нь хяналттай боловч давхар хяналт байхгүй, харилцагчид хүргэх арга хэлбэр нь олон төрлийн сонголттой тул бүрэн хянах боломжгүй, харилцагч зөвхөн зайнаас үйлчилгээ авах боломжтой.
3	Өндөр эрсдэлтэй (H-High)	Тухайн бүтээгдэхүүн үйлчилгээ нь МУТС үйл ажиллагаанд ашиглагдах эрсдэл өндөр, үйл ажиллагааны урсгал нь хяналтгүй, харилцагчид хүргэх арга хэлбэрийг хянах боломжгүй, харилцагч танин баталгаажуулалт хийлгүй, зайнаас үйлчилгээ авах боломжтой

Гурав. Байршлын эрсдэлийг үнэлэх

Байршлын эрсдэлийг үнэлэхдээ ББСБ-аас үзүүлж буй үйлчилгээг хүргэж буй газар зүйн байршлаас хамаарч дараах хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:

- Хөдөө, орон нутаг, Эдийн засгийн чөлөөт бүс (Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур, Хөшигийн хөндий)-д үзүүлсэн үйлчилгээ
- Гадаад улсад үзүүлсэн үйлчилгээ
- ФАТФ-аас МУТСТ тогтолцоо хангалтгүй гэж тодорхойлогдсон улс орнуудад үзүүлсэн үйлчилгээ
- Найдвартай эх сурвалжаас авлига хээл хахууль, бусад гэмт хэргийн гаралт өндөртэй гэж тодорхойлогдсон улс орнууд, бүс нутаг

Хүснэгт 3

№	Үнэлгээ	Тайлбар
1	Бага эрсдэлтэй (L-Low)	Монгол Улсад болон МУТС-тэй тэмцэх тогтолцоо, санхүүгийн хяналтын механизм сайн, олон улсын зохицуулагч байгууллагуудын хориг тавигдаагүй, хар болон саарал жагсаалтад бүртгэгдээгүй, авлига, хээл хахуулийн эсрэг хяналтын сайн системтэй, татварын ил тод орчин бүрдсэн, гэмт хэргийн гаралт бага улс орон, бүс нутаг
2	Дунд эрсдэлтэй (M-Moderate)	ФАТФ-ын хориг тавигдаагүй, хар жагсаалтад бүртгэгдээгүй боловч саарал жагсаалтад бүртгэлтэй, террорист ажиллагаа үйлдэгдэж болзошгүй бүс нутагт байрладаг, авлига, хээл хахуулийн эсрэг хяналтын системтэй боловч хэрэгждэггүй, сайжруулах шаардлагатай, татварын ил тод орчин бүрдсэн ч хангалттай бус, гэмт хэргийн гаралт бага эсвэл дунд
3	Өндөр эрсдэлтэй (H-High)	Тухайн улс орон нь МУТС-тэй тэмцэх тогтолцоо, санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй, ФАТФ-ын хориг тавигдсан эсвэл арга хэмжээ авагдаж байсан, хар ба саарал жагсаалтад бүртгэлтэй, террорист ажиллагаа үйлдэгддэг эсвэл үйлдэгдэж байсан бүс нутагт байрладаг, авлига, хээл хахуулийн эсрэг хяналтын систем хангалтгүй, татварын ил тод орчин бүрдээгүй, гэмт хэргийн гаралт өндөр

--ooOoo--